



**АХМАДЫН ХОТХОН-1 ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

**Хариуцлагатай эргүүл, жижүүр
томилох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх заалт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сар шинийн баярын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан 2017 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 09.00 цагаас 2017 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 09.00 цаг хүртэл ажиллах бүрэлдэхүүний хуваарийг хавсралтаар батлан, хотхоны аюулгүй байдал, харуул хамгаалалтыг өндөржүүлэн, үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавьж, цахилгаанчин, үйлчлэгч нарт үүрэг чиглэл өгч ажиллуулахыг Дулааны инженер /Г.Чулуунбаатар/-т үүрэг болгосугай.


2. Нийтээр амрах баярын өдөр ажилласны нэмэгдэл хөлсийг зохих журмын дагуу бодож олгохыг Нягтлан бодогч /С.Баяржаргал/-д зөвшөөрсүгэй.

3. Сар шинийн баяр амралтын өдрүүдэд ажилласан тухай дүнг 2017 оны 03 дугаар сарын 02-ны өдөр 10.00 цагт танилцуулахыг Дулааны инженер /Г.Чулуунбаатар/-т даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАТ



“Ахмадын хотхон-1” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын даргын 2017 оны 04 дугаар сарын 20-ны өдрийн 104 дугаар тушаалын хавсралт

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРГҮҮЛ, ЖИЖҮҮР, АЖИЛТНУУДЫН АЖИЛЛАХ ХУВААРЬ

д/д	Албан тушаал	Овог нэр	Өдөр	Тайлбар
1	Гэрээний мэргэжилтэн	Г.Батсанаа	2017.02.26 09:00- 2017.02.27 09:00	Хариуцлагатай эргүүл
2	Дулааны инженер	Г.Чулуунбаатар	2017.02.27 09:00- 2017.02.28 09:00	Хариуцлагатай эргүүл
3	Гэрээний мэргэжилтэн	О.Мөнхтуяа	2017.02.28 09:00- 2017.03.01 09:00	Хариуцлагатай эргүүл
4	Нягтлан бодогч	С.Баяржаргал	2017.03.01 09:00- 2017.03.02 09:00	Хариуцлагатай эргүүл
5	Цахилгаанчин	Л.Пүрэвдорж	2017.02.26 2017.02.28	Өдөр бүр
6	Үйлчлэгч	С.Отгонбаяр	2017.02.26 2017.02.28	Өдөр бүр
7	Үйлчлэгч	Д.Түмэндэлгэр	2017.02.26 2017.02.28	Өдөр бүр
8	Үйлчлэгч	Н.Батбаяр	2017.02.26 2017.02.27	Өдөр бүр